



74

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2012 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын "Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудлуудын ажилчдын мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээнийг 2012 оны 12 сарын 4-нөөс 5-ны өдрүүдэд зохион байгуулахыг үйлчилгээний байгууллага хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

2. Мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Тэмцээн зохион байгуулахад шаардагдах төсөв 1.480.000 /нэг сая дөрвөн зуун наян мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээнийг цаг хугацаанд нь зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг үйлчилгээний байгууллага хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА



Ш.СҮХБААТАР



Зочид буудлын үйлчилгээний ажилчдын мэргэжлийн
аврага шалгаруулах тэмцээний төсөв

д/д	Барааны нэр	Тоо ширхэг	үнэ	Нийт	Хянасан
1	Тэмцээнд шаардагдах материалын зардал	-		175.000	Зочид буудлын холбоо
2	Өргөмжлөл	12	50.000	600.000	Зочид буудлын холбоо
3	Шагнал	7	90.000	630.000	
4	Шагналын Х.А.О.А.Т	7	10.000	70.000	
5	Шүүгчдийн ажлын хөлс	7*2 өдөр	50.000	640.000	
6	Шүүгчдийн Х.А.О.А.Т	7*2 өдөр	5.000	140.000	
7	Зохион байгуулагч, шүүгчдийн өдрийн хоол, ус ундаа	10*2 өдөр	10.000	200.000	Зочид буудлын холбоо
8	Зохион байгуулагчдийн унааны зардал	2 өдөр		20.000	Зочид буудлын холбоо
9	Нийт дүн			2.475.000	
10	Аялал жуулчлалын газраас			1.480.000	
11	Зочид буудлын холбоо			995.000	